

# ХЭНТИЙ АЙМАГ ГАЛШАР СУМ



## ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН АРДЧИЛСАН НАМААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020.06.23



**ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНЫ 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ЗОРИЛГО:** Өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж,ажилтай орлоготой, эрүүл чийрэг,эрдэм боловсролтой, эрх чөлөөт иргэнээ эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах боломж,нөхцлийг бүрдүүлэх, байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлого зорилтыг хэрэгжүүлнэ.

**УРИА:** ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ

**НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ /Боловсрол, Эрүүл мэндийн үйлчилгээ, Өрх гэр бүл ,хүүхэд,Нийгмийн хамгаалал, Аялал жуулчлал, спорт урлаг ХӨГЖЛИЙГ ХҮРТЭХ ХЭНТИЙЧҮҮД / ХӨГЖЛИЙГ ХҮН БҮРТ**

- 1.1. Галшар сумын ирээдүйн иргэн хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, байгаль, түүх, соёл уламжлалаараа бахардаг “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2. “Оюунлаг Галшарчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3. “Хэнтийн ирээдүй- багшийн хөгжил”хөтөлбөрийн хүрээнд багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан тийм сургах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 1.4. Сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийг шинээр бариулж ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 1.5. Төрийн бодлогоор хэрэгжих “Түмэн инженер” хөтөлбөрт орон нутгаас суралцах боломжийг эрс нэмэгдүүлнэ.
- 1.6. Орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн боловсон хүчнийг аймгийн МСҮТ-д бэлтгэнэ.
- 1.7. Нутгийн боловсон хүчнийг дэмжих хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.8. Чөлөөт цагаа өнгөрүүлэх, бие бялдараа хөгжүүлэх, спортоор хичээллэхэд зориулсан хүүхэд залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулна.
- 1.9. ЭМТ-ийн барилгад их засвар хийлгэх
- 1.10. Иргэн бүрийг насны бүлэгт тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.
- 1.11. Эрүүл мэндийн төвийг шинэ тутам гарч буй шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.12. Эмч нарыг нарийн мэргэжлийн сургалтанд хамруулна. Шүдний эмчийн асуудлыг шийдвэрлэн шүдний кабинетийг тогтмол ажиллуулна.
- 1.13. Уламжлалт эмчилгээ, үйлчилгээг бий болгоно.
- 1.14. Иж бүрэн тоноглол бүхий сүүлийн үеийн автомашинаар ЭМТ-ийг хангуулна.
- 1.15. Архигүй Галшар-2 хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.16. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг хэвшүүлэн “Эрүүл мэндийг дэмжигч” сум болно.
- 1.17. Сумын хэмжээнд гэр бүлийн гишүүн бүрт ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 1.18. Залуу гэр бүл, зорилтот бүлгийн өрхүүдийг түрээсийн орон сууцаар хангах ажлыг эхлүүлнэ.
- 1.19. Соёлын төвийн барилгыг шинээр бариулна.

- 1.20. Соёл амралтын хүрээлэнгийн зориулалтаар ашиглах боломж бүхий наадмын талбайг шинээр байгуулна.
- 1.21. Хужиртын төв, Сүмийн хадыг түшиглэн түүхэн болон байгалийн аялал жуулчлалыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлнэ.

**ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ / Жижиг дунд бизнес, Хөдөлмөрийн зах зээл, Аж үйлдвэрлэлийн салбар, Дэд бүтэц, Эрчим хүч, Барилгын салбар, Шинжлэх ухаан технологи, Аялал жуулчлал/**

- 2.1. Малын гаралтай түүхий эд, арьс шир боловсруулах, дайвар бүтээгдхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрүүдийг бодлогоор дэмжинэ.
- 2.2. Сумын мал эмнэлгийн тасгийг зориулалтын барилга, тоног төхөөрөмж, автомашинаар хангах
- 2.3. Хөдөө аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэн тогтвор суурьшилтай ажиллуулах талаар аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
- 2.4. Галшарын улаан ямааны судалгааны ажлыг үргэлжлүүлж “Үүлдэр”-ээр батлуулах асуудлыг шийдвэрлүүлэх
- 2.5. ЖДҮДСангийн хөрөнгө санхүүгийн дэмжлэгээр Ноолуур угаах, самнах үйлдвэрийг байгуулж бүтээгдхүүнийг экспортонд гаргах
- 2.6. Малын тооноос- чанарт” уриалгыг гаргаж аймаг, сумын сайн малчдыг шалгаруулах журамд бэлчээрийг хамгаалах, усжуулах, орон нутгийн хөгжилд оруулсан бодитой хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр ашгийг тооцдог шалгуурыг оруулах
- 2.7. Чинээлэг малчин” хөтөлбөрийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 2.8. Шинэ зууны малчин” хөтөлбөрийн хүрээнд малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан эх үүсвэрээр хангах асуудлыг шийдвэрлүүлнэ.

**ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ / Орон нутгийн хөгжил, Шинэ сум, хөдөө аж ахуй, Бэлчээр,Газартариалан, НУТАГТАА ЭЗЭН ХЭНТИЙЧҮҮД**

- 3.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулж мөрдүүлнэ
- 3.2. Сумын төвийн инженерийн шугам сүлжээний ажлыг дуусгаж орчин үеийн тохижилт бүхий дэд бүтэц хөгжсөн “Жишиг сум” болох зорилтыг хэрэгжүүлнэ.
- 3.3. Сумын төвд “Хашаандаа сайхан амьдрая”, “Жорлонгоо өөрчилъе” төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 3.4. Иргэдийн санал санаачилга, оролцоонд тулгуурлан сумын хилийн цэсийг тодотгон баталгаажуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 3.5. Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулах
- 3.6. Сумын хэмжээнд байгаа гол, булаг, шанд, нуур, цөөрмийг хамгаалалтад авч байгалийн тэнцвэрт байдлыг хангана.
- 3.7. Гадаад дотоодын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран унлага, хурдны Галшар үүлдрийн адуу, ноолуурын чиглэлийн Галшар омгийн улаан ямааны удам зүйн судалгааг гүнзгийрүүлнэ.
- 3.8. Банкны үйлчилгээг нэмэгдүүлж Интернет банк-АТМ ийг байршуулах.

**ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ/ Иргэнээ хамгаалдаг хууль, ХУУЛИЙГ ДЭЭДЛЭГЧ ХЭНТИЙЧҮҮД**

231714429  
310A0046 907

- 4.1. "Эрх зүйн хөтөч" хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж мэдээллээр хангах ажлыг тогтмолжуулна
- 4.2. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах ажлыг зохион байгуулах,
- 4.3. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангуулж гамшгийн эрсдлийг бууруулна.

**ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ / Байгаль орчин, ногоон хөгжил /**

- 5.1. Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгын зүй бус ашиглалтыг зогсоох , жам ёсоор нөхөн сэргээх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг сайжруулсан байгальд ээлтэй сум болгоно.
- 5.2. Иргэн бүр-Нэг мод" төслийг хэрэгжүүлэн сумын ногоон байгууламж бүхий талбайн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж үр дүнгээр нь урамшуулна.
- 5.3. "Байгальд ээлтэй малчин"шалгаруулах журмыг сумын ИТХ-аар батлуулж жил бүр шалгаруулна.
- 5.4. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх ажлыг хийнэ.
- 5.5. Олон наст, тэжээлийн ургамал тариалах иргэд, малчдын бүлгийг бодлогоор дэмжих
- 5.6. Ховор, нэн ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарималжуулах ажлыг дэмжин ажиллана.
- 5.7. Уул уурхайн чиглэлээр олгогдсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг цөөлөх замаар " Лицензгүй сум" болох зорилтыг хэрэгжүүлж эхэлнэ.
- 5.8. Рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулна.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

ГАЛШАР СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА



Б.ЭНХТАЙВАН

